



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 692

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 9 нэрийн, нийт 14,347,583.00 (арван дөрвөн сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун наян гурван) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 4,150,000.00 (дөрвөн сая нэг зуун тавин мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад шилжүүлэн хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007613

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дугаар сарын 28-ны өдрийн
69/ дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭГТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр төрөл	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа				Шилжүүлэх байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллагын нэр
					Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ		
1	Металл элдэгч	1	4,500,000.00	4,500,000.00	3	1	800,000.00	800,000.00	Мэргэжил сургалт	421 дүгээр нээлттэй хорих анги
2	Металл цуйвж сунгах машин	1	5,000,000.00	5,000,000.00	3	1	1,000,000.00	1,000,000.00	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	
	Дүн			9,500,000.00				1,800,000.00		
3	Ёочин	1	716,599.00	716,599.00	3	1	350,000.00	350,000.00	Төв аппарат	Сүлд БТСХороо
4	Ёочин /жижиг/	1	632,293.00	632,293.00	3	1	300,000.00	300,000.00		
5	Хуучир	1	526,911.00	526,911.00	3	1	250,000.00	250,000.00		
6	Хуучир /жижиг/	1	358,300.00	358,300.00	3	1	200,000.00	200,000.00		
7	Шанз	2	632,293.50	1,264,587.00	3	2	300,000.00	600,000.00		
8	Ятга	1	758,752.00	758,752.00	3	1	350,000.00	350,000.00		
9	Ятга /жижиг/	1	590,141.00	590,141.00	3	1	300,000.00	300,000.00		
	Дүн			4,847,583.00				2,350,000.00		
	Нийт дүн			14,347,583.00 (арван дөрвөн сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун наян гурван)				4,150,000.00 (дөрвөн сая нэг зуун тавин мянган)		